

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Тариалан сумын ерөнхий боловсролын сургуулийн  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн  
аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/205/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Мөрөн сум 2024 он</p>	<p>Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: <a href="mailto:erdenebaatara@audit.gov.mn">erdenebaatara@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: <a href="mailto:tegshdelgerb@audit.gov.mn">tegshdelgerb@audit.gov.mn</a> Аудитор: Г.Ичинхорлоо Утас: 88688168 Цахим хаяг: <a href="mailto:ichinkhorloog@audit.gov.mn">ichinkhorloog@audit.gov.mn</a> Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн захирал Б.Мядагмаа Утас: 99389208 Цахим хаяг: <a href="mailto:b_myadagmaa@yahoo.com">b_myadagmaa@yahoo.com</a> Аудитор Д.Оюундаваа Утас: 99382220 Цахим хаяг: <a href="mailto:oyundavaa@gmail.com">oyundavaa@gmail.com</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.26 № 01/149  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТАРИАЛАН  
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Ч.БАТЧУЛУУН ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 77,719.6 мянган төгрөгөөр, өглөгийн дүн 79,684.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

#### Аудитын гол асуудал

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих болон цахим хэрэглээний зардал, танхимаас гадуур сургалтын хөтөлбөр арга хэмжээний батлагдсан зардлаас 4,600.0 мянган төгрөгийг зориулалт арга хэмжээний дагуу зарцуулаагүй байна. Мөн оны эцэст цахим хэрэглээний зардлаас 2,730.0 мянган төгрөгийг урьдчилж шилжүүлээд санхүүгийн тайланд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй зөрчил тус тус илэрч зөвлөмж өглөө.

#### Аудитын бусад асуудал

Тариалан сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 11 зорилт, 51 арга хэмжээ төлөвлөн 81.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

6724040328

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>438,003,131.81</b>	<b>518,356,332.17</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>289,953,730.00</b>	<b>367,673,101.08</b>
<b>31200</b>	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>289,953,730.00</b>	<b>367,673,101.08</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>289,953,730.00</b>	<b>367,673,101.08</b>
31211	Төрийн сангийн харилцах	289,953,730.00	367,673,101.08
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>3,951,294.00</b>	<b>410,915.72</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,951,294.00	410,915.72
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>144,098,107.81</b>	<b>150,272,315.37</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>2,181,000.00</b>	<b>1,493,000.00</b>
35130	Эм боох материал	2,181,000.00	1,493,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0	7,405,000.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>141,917,107.81</b>	<b>141,374,315.37</b>
35410	Бичиг хэргийн материал	857,100.00	939,100.00
35420	Аж ахуйн материал	42,882,018.10	32,091,654.60
35430	Сэлбэг хэрэгсэл	0	239,144.50
35440	Түлш, шатах тослох материал	0	927,675.00
35450	Барилгын засварын материал	741,000.00	503,000.00
35460	Хүнсний материал	31,421,940.00	34,956,406.40
35470	Бусад хангамжийн материал	66,015,049.71	71,717,334.87
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,416,040,924.89</b>	<b>2,486,758,229.53</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,416,040,924.89</b>	<b>2,486,758,229.53</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,296,503,141.50</b>	<b>2,371,774,508.47</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,595,958,771.44	2,595,958,771.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-598,202,014.24	-684,478,318.28
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	280,048,013.98	442,366,266.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-95,803,688.81	-160,224,103.42
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	119,520,610.12	189,661,897.12
39208	Хуримтлагдсан элэгдэл	-80,679,236.14	-91,617,135.82
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,965,171.26	17,965,171.26
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,087,229.81	-9,540,751.41
39217	Ном	65,782,743.70	71,682,710.60
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>119,537,783.39</b>	<b>114,983,721.06</b>
39301	Программ хангамж	15,248,645.00	15,248,645.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,784,861.61	-10,338,923.94
39303	Бусад биет бус хөрөнгө	110,074,000.00	110,074,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,854,044,056.70</b>	<b>3,005,114,561.70</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>79,684,687.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>0</b>	<b>79,684,687.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>0</b>	<b>79,684,687.00</b>
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>79,684,687.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	79,684,687.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,854,044,056.70</b>	<b>2,925,429,874.70</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,854,044,056.70</b>	<b>2,925,429,874.70</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,200,377,201.03	1,200,377,201.03
5E+05	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,200,377,201.03	1,200,377,201.03
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-204,223,260.06</b>	<b>-132,837,442.06</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-3,137,775,509.16	-204,223,260.06
51220	Тайлант үеийн үр дүн	2,933,552,249.10	71,385,818.00

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,857,890,115.73	1,857,890,115.73
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,854,044,056.70</b>	<b>3,005,114,561.70</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>3,030,872,987.40</b>	<b>3,324,537,606.43</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>94,435,187.40</b>	<b>69,540,606.43</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	94,435,187.40	<b>69,540,606.43</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	94,435,187.40	<b>6,953,300.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	94,435,187.40	6,953,300.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		52,664,966.90
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	94,435,187.40	9,922,339.53
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,930,084,500.00</b>	<b>3,254,997,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,467,908,600.00</b>	<b>2,868,885,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,467,908,600.00	2,868,885,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>462,175,900.00</b>	<b>386,111,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	462,175,900.00	386,111,700.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,738,506,073.74</b>	<b>3,253,151,788.43</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,738,506,073.74</b>	<b>3,253,151,788.43</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,598,242,083.74</b>	<b>3,089,756,743.43</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,620,474,206.00</b>	<b>2,004,061,873.29</b>
210101	Үндсэн цалин	1,206,096,750.00	1,432,532,239.48
210102	Нэмэгдэл	370,551,874.00	480,565,292.81
210104	Урамшуулал	43,825,582.00	90,964,341.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>203,360,500.00</b>	<b>256,119,515.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	140,215,568.67	174,830,393.45
210202	Тэтгэмжийн даатгал	16,187,260.87	20,485,179.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,084,769.85	16,463,223.02
210204	Ажилгүйдлийн даатгал	3,257,700.44	4,030,823.20
210205	Эрүүл мэндийн даатгал	32,615,200.17	40,309,896.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>365,120,900.00</b>	<b>370,647,130.50</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	13,691,643.50
210302	Түлш, халаалт	350,120,900.00	347,955,487.00
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	9,000,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,673,350.00</b>	<b>67,027,991.87</b>
210401	Бичиг хэрэг	2,105,000.00	3,990,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,737,250.00	10,862,050.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	3,067,424.00
210404	Ном, хэвлэл	0	6,953,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,831,100.00	18,431,300.00
210408	Бараа материал акталсны зардал	0	23,723,917.87
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>146,657,690.00</b>	<b>165,902,075.35</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,585,000.00	2,687,990.00
210502	Хоол, хүнс	144,072,690.00	163,214,085.35
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>16,953,900.00</b>	<b>8,761,000.00</b>
210604	Урсгал засвар	16,953,900.00	8,761,000.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>912,000.00</b>	<b>1,968,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	912,000.00	1,968,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>11,441,300.00</b>	<b>14,723,354.51</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,353,300.00	0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,080,000.00	14,723,354.51
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>206,648,237.74</b>	<b>200,545,802.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,141,400.00	21,204,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,544,180.00	11,699,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	173,962,657.74	167,642,202.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>140,263,990.00</b>	<b>163,395,045.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>140,263,990.00</b>	<b>163,395,045.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	140,263,990.00	140,805,445.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	22,589,600.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>292,366,913.66</b>	<b>71,385,818.00</b>
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>292,366,913.66</b>	<b>71,385,818.00</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,936,437,800.00</b>	<b>3,261,950,300.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,353,300.00</b>	<b>6,953,300.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,353,300.00</b>	<b>6,953,300.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>6,353,300.00</b>	<b>6,953,300.00</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,353,300.00	6,953,300.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,930,084,500.00</b>	<b>3,254,997,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,467,908,600.00</b>	<b>2,868,885,300.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,467,908,600.00	2,868,885,300.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>462,175,900.00</b>	<b>386,111,700.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	462,175,900.00	386,111,700.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,566,633,570.00</b>	<b>3,078,221,075.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,566,633,570.00</b>	<b>3,078,221,075.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,426,369,580.00</b>	<b>2,907,406,310.92</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,624,425,500.00</b>	<b>2,000,521,495.01</b>
210101	Үндсэн цалин	1,203,860,591.00	1,428,991,861.20
210102	Нэмэгдэл	362,337,926.00	480,565,292.81
210104	Урамшуулал	58,226,983.00	90,964,341.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>203,360,500.00</b>	<b>256,119,515.65</b>
210201	Тэтгэврийн даатгал	138,168,100.00	174,830,393.45
210202	Тэтгэмжийн даатгал	16,540,600.00	20,485,179.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,778,900.00	16,463,223.02
210204	Ажилгүйдлийн даатгал	3,257,700.00	4,030,823.20
210205	Эрүүл мэндийн даатгал	32,615,200.00	40,309,896.21
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>361,825,900.00</b>	<b>373,111,700.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	10,000,000.00	12,303,670.14
210302	Түлш, халаалт	346,825,900.00	353,163,885.36
210303	Цэвэр, бохир ус	5,000,000.00	7,644,144.50

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>146,270,450.00</b>	<b>166,732,231.75</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0	0
210502	Хоол, хүнс	146,270,450.00	166,732,231.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	0	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>15,000,000.00</b>	<b>13,000,000.00</b>
210604	Урсгал засвар	15,000,000.00	13,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>10,433,300.00</b>	<b>24,328,578.51</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,353,300.00	6,953,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,080,000.00	17,375,278.51
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>65,053,930.00</b>	<b>73,592,790.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,140,100.00	63,016,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,913,830.00	10,575,800.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>140,263,990.00</b>	<b>170,814,765.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>140,263,990.00</b>	<b>170,814,765.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	140,263,990.00	148,226,765.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0	22,588,000.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>369,804,230.00</b>	<b>183,729,224.08</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>79,850,500.00</b>	<b>106,009,853.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>79,850,500.00</b>	<b>106,009,853.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>79,850,500.00</b>	<b>106,009,853.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	79,850,500.00	106,009,853.00
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-79,850,500.00</b>	<b>-106,009,853.00</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>289,953,730.00</b>	<b>77,719,371.08</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	289,953,730.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	289,953,730.00	367,673,101.08

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

<b>2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,200,377,201.03</b>	<b>1,857,890,115.73</b>	<b>-204,223,260.06</b>	<b>2,854,044,056.70</b>
<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>1,200,377,201.03</b>	<b>1,857,890,115.73</b>	<b>-204,223,260.06</b>	<b>2,854,044,056.70</b>
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,200,377,201.03</b>	<b>1,857,890,115.73</b>	<b>-204,223,260.06</b>	<b>2,854,044,056.70</b>
Тайлант үеийн үр дүн	0	0	71,385,818.00	71,385,818.00
<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,200,377,201.03</b>	<b>1,857,890,115.73</b>	<b>-132,837,442.06</b>	<b>2,925,429,874.70</b>

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	зөрүү	хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,144,187,600.00</b>	<b>2,798,119,228.92</b>	346,068,371.08	89
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,144,187,600.00</b>	<b>2,798,119,228.92</b>	346,068,371.08	89
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,947,224,700.00</b>	<b>2,627,304,463.92</b>	319,920,236.08	89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,266,322,900.00</b>	<b>2,000,521,495.01</b>	265,801,404.99	88
210101	Үндсэн цалин	1,541,127,700.00	1,428,991,861.20	112,135,838.80	93
210102	Нэмэгдэл	615,174,200.00	480,565,292.81	134,608,907.19	78
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0	0	0.00	0
210104	Урамшуулал	110,021,000.00	90,964,341.00	19,056,659.00	83
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>283,290,400.00</b>	<b>256,119,515.65</b>	27,170,884.35	90
210201	Тэтгэврийн даатгал	192,637,500.00	174,830,393.45	17,807,106.55	91
210202	Тэтгэмжийн даатгал	22,663,200.00	20,485,179.77	2,178,020.23	90
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,130,600.00	16,463,223.02	1,667,376.98	91
210204	Ажилгүйдлийн даатгал	4,532,600.00	4,030,823.20	501,776.80	89
210205	Эрүүл мэндийн даатгал	45,326,500.00	40,309,896.21	5,016,603.79	89
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>186,835,300.00</b>	<b>166,732,231.75</b>	20,103,068.25	89
210502	Хоол, хүнс	186,835,300.00	166,732,231.75	20,103,068.25	89
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>24,328,600.00</b>	<b>24,328,578.51</b>	21.49	100
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	6,953,300.00	6,953,300.00	0.00	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	17,375,300.00	17,375,278.51	21.49	100
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>186,447,500.00</b>	<b>179,602,643.00</b>	6,844,857.00	96
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	160,384,500.00	153,539,643.00	6,844,857.00	96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	26,063,000.00	26,063,000.00	0.00	100
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>196,962,900.00</b>	<b>170,814,765.00</b>	26,148,135.00	87
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>196,962,900.00</b>	<b>170,814,765.00</b>	26,148,135.00	87
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	174,374,900.00	148,226,765.00	26,148,135.00	85
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,588,000.00	22,588,000.00	0.00	100
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>3,144,187,600.00</b>	<b>2,875,838,600.00</b>	268,349,000.00	91

<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,868,885,300.00</b>	<b>2,868,885,300.00</b>	0.00	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,868,885,300.00	2,868,885,300.00	0.00	100
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>275,302,300.00</b>	<b>6,953,300.00</b>	268,349,000.00	3
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,953,300.00	6,953,300.00	0.00	100
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	268,349,000.00	0	268,349,000.00	0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	289,953,730.00	289,953,730.00	0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	367,673,101.08	367,673,101.08	0

## 2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

данс	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
210	Бараа, үйлчилгээний зардал	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	373,111,700.00	373,111,700.00	-	100.0
210301	Гэрэл цахилгаан	14,000,000.00	12,303,670.14	1,696,329.86	87.9
210302	Түлш, халаалт	350,111,700.00	353,163,885.36	-3,052,185.36-	100.9
210303	Цэвэр, бохир ус	9,000,000.00	7,644,144.50	1,355,855.50	84.9
2106	Эд хогшил худалдан авах	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
210604	Урсгал засвар	13,000,000.00	13,000,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
132001	Орон нутгийн төсвөөс	386,111,700.00	386,111,700.00	-	100.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7,330.0 мянган төгрөгийн зерчил илэрч, алдааг дахин давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой залруулгын алдаа илрээгүй болно.

Нийт илрүүлсэн 7,330.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 36,486.0 мянган төгрөгөөр бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өглөө

### **3.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Тус сургуулийн үндсэн хөрөнгөнд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 103 нэр төрлийн 261,219.3 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн параграф 67, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах,” заалт болон ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7 дугаар бүлгийн 7.1 заалттай тус тус нийцээгүй, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг ОНӨГ-т хүргүүлэн шийдвэрлүүлж, үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгах

#### **2. Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт:

Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих зардлаас 3,750.0 мянган төгрөгийг нэг удаагийн тэтгэмж урамшуулалд, танхимаас гадуур сургалтын зардлаас 400.0 мянган төгрөгийг багш нарын сургалтанд зарцуулсан, цахим хэрэглээний зардлаас нягтлан бодогч нярав эмч нарт 450.0 мянган төгрөгийн дата олгосон нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах,” заалт, БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалын 2 дүгээр хавсралтаар баталсан “Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйл ажиллагааны санхүүжилт, түүнийг зарцуулах заавар”, 3-р хавсралтаар баталсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн цахим хэрэглээний зардлыг төлөвлөх, хуваарилах заавар” болон үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Төсвийг батлагдсан зориулалт, арга хэмжээний дагуу, холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн зарцуулж байх.

#### **3.Төсвийн гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

##### Илрүүлэлт

Цахим хэрэглээний батлагдсан зардлаас оны эцэст Мобиком ХХК-д 1,200.0 мянган төгрөг Юнител ХКК-д 1,530.0 мянган төгрөг нийт 2,703.0 мянган төгрөгийг 2024 оны датаны хэрэглээнд зориулж урьдчилан шилжүүлсэн боловч тайлант онд урьдчилж төлсөн зардлаар бүртгээгүй байгаа нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.26 “Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн төлбөр/зардал/ гэнэ. Энэ нь төлбөр хийгдсэн боловч тайлант хугацаанд гараагүй байгаа зардал учраас хөрөнгө гэж бүртгэнэ” заалт, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

##### Өгсөн зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, журам зааврыг мөрдөж ажиллах

#### 4. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Сургуулийн гал тогоо, үдийн цай, талхны газар, халуун усанд хэрэглэж байгаа түлээний зарцуулалтыг хянан үзэхэд тухай бүр түлээний зарлагын баримт үйлдээгүй, тайлант жилд зөвхөн 6 удаагийн шаардах хуудсаар зарлага болгосон нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4. "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" заалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Түлээний зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж анхан шатны баримт тухай бүр үйлдэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 1. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг дахин тооцоогүй	1	0					1	0				
Төсвийн хөтөлбөр арга хэмжээний ангилал зөрчин зарцуулсан	1	4,600.0					1	4,600.0				
Урьдчилж гарсан зардлыг бүртгэлд тусгаагүй	1	2,730.0					1	2,730.0				
Түлээний зарцуулалтад анхан шатны баримт бүрэн үйлдээгүй	1	0					1	0				
Дүн	4	7,330.0					4	7,330.0				